



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/672

Булган сум

Г "Булган мандал хийморь" ХХК-д дэмжлэг үзүүлэх тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймаг, Уулын баяжуулах "Эрдэнэт Үйлдвэр" Төрийн Өмчит Үйлдвэрийн газрын 2024 хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шинээр ажлын байр нэмэгдүүлэх ажлын сонгон шалгаруулалтад "Булган мандал хийморь" ХХК шалгарсан тул 18,600,000 (арван найман сая зургаан зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Төсөл арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд чанарын өндөр түвшинд зохион байгуулж, зарцуулалтыг тайлагнахыг "Булган мандал хийморь" ХХК (Д.Доржпүрэв)-д, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т үүрэг болгосугай.

3. Дээрх хөрөнгийг Булган аймаг, Уулын баяжуулах "Эрдэнэт үйлдвэр" Төрийн Өмчит Үйлдвэрийн газрын 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ